As mentioned in the first part of the study, financial depth is one of the indicators of the development of the financial sector. This chapter (part) estimated the impact of financial depth on economic growth in the case of Mongolia, using data from 1991-2018, and a list, description, and sources used for the study are shown in Table 2.

Given the empirical research in this area and the availability of data, the depths of the banking sector were chosen as the ratio of bank credits to GDP and the depth of the financial market was chosen as the ratio of stock market turnover. Other explanatory variables include the human capital index, government spending, inflation, and open economic environment which are based on a model developed by the International Bank for Settlements (BIS) researchers.

Table 2. Definition of the study variables

Variables	Definitions	Resources
GDPG	GDP per capita growth (annual %)	World bank
DC	DOMESTIC CREDIT TO PRIVATE SECTOR (% OF GDP)	World bank
GE	Government expenditure to GDP	countryeconomy.com
DM	The turnover ratio of the stock market	World bank, tradingeconomics.com, www.theglobaleconomy.com
TB	Trade balance (% GDP)	countryeconomy.com
HC	Human capital index per capita	Penn World Table 9.1
INF	Inflation calculated by the consumer price index	World bank

4.3. Factor Agility Analysis

Most time series data is unstable. Therefore, the data used in the study was tested using ADF and PP tests.

Table 3. The results of unit root tests

	H_0 : Unit root process					
	Fisher-ADF			Fisher-PP		
	Intercept	Trend&Intercept	None	Intercept	Trend&Intercept	None
GDPG	0.0404**	0.0261**	0.0318**	0.0284**	0.2259	0.0336**
DC	0.9343	0.1815	0.9289	0.9468	0.1867	0.9474
GE	0.0110**	0.0027***	0.3475	0.0097***	0.0024***	0.3292
DM	0.1944	0.0917*	0.0266**	0.1944	0.1250	0.1480
TB	0.0271**	0.0091***	0.7530	0.0295**	0.0096***	0.9209
HC	1.0000	0.9994	0.9766	1.0000	0.8811	1.0000
INF	0.0000***	0.0002***	0.0254**	0.1806	0.1014	0.0430**

Source: Estimates of Researchers

Note: Zero hypotheses are shown with the smallest probability of rejection, and (*), (**), (***) indicate significance at 10%, 5%, and 1% significance level, respectively.

For example, Table 3 shows that GDPG recognizes a constant variable and is stable at a simple level with 95 percent significance. With these tests, the variables GDPG, GE, TB, and

INF were stable, but the variables DC, DM, and HC were unstable at their normal level and were used in the study by logarithm.

4.4. The empirical findings

To investigate the impact of financial depth on economic growth, we have used the following equation of econometric estimation least

squares (OLS), and have compiled the equation below here.

Table 4. Estimation results

Variable	Coefficient	T-Statistic
C	-2.075***	-3.078
GDPG(-1)	0.369*	2.093
LOG(DC(-1))	-0.005**	-2.831
LOG(DM)	-0.005***	-3.495
TB	0.278***	4.329
GE	-0.540**	-2.268
GE(-1)	-0.878***	-3.355
INF	0.003**	2.718
INF(-1)	0.002***	3.241
LOG(HC(-1))	3.301**	2.281
R-squared	0.743	
F-statistic	3.46**	
S.E. of regression	0.029	
Durbin-Watson stat	1.637	

Source: Estimates of Researchers

Note: (*), (**), (***) indicates that the rejection of zero assumptions that is not influenced by the model at the significance level of 10%, 5%, and 1%.

It is statistically significant that the results show that indicators such as the ratio of the domestic debts to the private sector to GDP, and the stock market turnover ratio could have a negative impact on real GDP growth per capita. This is partly due to the fact that Mongolia is too dependent on its banking sector which accounts for about 95% of the whole financial system in the country. On the other hand, it is in line with the empirical results of the research showing that

excessive financial depth in less developed financial markets results in a loss of financial stability and a negative effect on real economic growth.

Also we assume that Mongolian financial depth doesn't affect its own economic growth nonlinearly. The reason can be that for low-income countries, the effect of financial depth on economic growth is relatively small or weak.

For other variables, human capital (HC) and foreign trade openness (TB) have a positive effect on economic growth (GDPG), while government spending/ expenditure indicator (GE) has a negative effect on growth.

5. CONCLUSIONS

In the first part (chapter) of this study, we compared some indicators of the financial sector of Mongolia with international level, using the World Bank's financial sector development methodology. For example, in the banking sector, such as the depth, efficiency and stability are at an average level among low and lower middle income countries and at above average level for its financial services accessibility indicators. However, the development of financial institutions and financial markets other than banks were at significantly lower level when compared to the average income-earning countries (Shown in table 5).

Table 5. The level of development of the financial sector of Mongolia as compared to the average of low and lower middle income countries:

	Indicators for measuring the development of the financial sector	Comparison
Depth	A. Financial institutions	Approximately the same
	• Bank	Approximately the same
	• Non -banking organizations	Below
	B. Financial markets	Below
Access	A. Bank	Higher
	B. Financial markets	Not calculated
Efficiency	A. Bank	Approximately the same
	B. Financial markets	Below
Stability	A. Bank	Higher
	B. Financial markets	Below

Source: Estimates of Researchers

Then we estimated the impact of financial depth on the real economy, one of the measurements for evaluating the development of the financial sector. To do so, we assessed the non-linear effects on economic growth using OLS model and considered the depth of banking sector and stock market.

The study results shows that the key variables were consistent with theoretical assumptions and also that each of the indicators of the banking and financial market depth negatively affected real economic growth (non-linear effects were negligible). In other words, we assume that for low-income countries, the effect of

financial depth on economic growth is relatively small or weak. From a financial institution's view, in Mongolia, due to the banking sector alone accounting for about 95% of the financial system, excessive financial depth takes place. Then the risk is accumulated by excess leverage in the economy, which has a negative effect on the real economy.

However, from a financial market's view, the following factors such as the activation of the stock market, weak profitability, or very high uncertainty or fluctuations in the stock price index could have a negative effect on the real economy when the financial depth takes place.

REFERENCES

1. Adolfo Barajas, Ralph Chami, Seyed Reza Yousefi. (2012). The Finance and Growth Nexus Re-examined: Do all Countries Benefit Equally. *IFM*.
2. Alves, J., & Afonso, A. (2015). The Role of Government Debt in Economic Growth. www.researchgate.net/publication/281556458.
3. Goldsmith.RW. (1969). Finance Structure and Development. *Yale University Press*. New Haven, CT.
4. He, H., Lu, J., & Mano, C. (2018). China's High Savings: Drivers, Prospects, and Policies. *IMF Working Paper*.
5. Hoi, L., Ho, H., & Vu, T. (2019). Financial depth and economic growth: Empirical evidence from ASEAN+3 countries. *Management Science Letters*. 9. . 10.5267/j.msl.2019.3.003, 851-864.
6. Hundie, S. K. (2016). *Savings, Investment and Economic growth in Ethiopia: Evidence from Bouds testing conintegration and TYDL Granger-Causality tests*. Saarbrucken: Lap Lambert Academic publishing.
7. Ivic, M. (2015). Economic Growth and Development. *Journal of Process Management - New Technologies, International, Vol. 3, No.1*.
8. King, R, & Levine, R. (1993). Finance and growth: Schumpeter. *Quarterly Journal of Economics*, 108, 717-738.
9. Lau, L. J. (2018). A Better Alternative to a Trade War. *SSRN online publication, No4, 4*.
10. Lenardo Gambacorta, Jing Yang, Kostas Tsatsaronis. (2014). Financial structure and growth. *BIS Quarterly Review*.
11. Levine, R. (2004). Finance and Growth: Theory and Evidence. *NBER, Working paper 10766*.
12. Lucas.R. (1988). On the mechanics of economic development. *Journal of Monetary Economics*, 22(1), 3-42.
13. McKinnon, RI . (1973). Money and Capital in Economic Development. *Brookings Institute*. Washington D.C.
14. Murty, K., Sailaja, K., & Demissie, W. (2012). The Long-Run Impact of Bank Credit on Economic Growth in Ethiopia: Evidence from the Cointegration App. *European Journal of Business and Management*, 4, ISSN 2222-1905.
15. Myagmarsuren.S. (2015). The financial depth, and its impact estimation on the real economic sectors. *Mongolian central bank's research compilation*, 10. Ulaanbaatar, Mongolia.
16. Robert G. King, & Ross Levine. (1993). Finance and Growth: Schumpeter might. *Quarterly Journal of Economics*, 108 (3), 717-37.
17. Robinson.J. (1952). The Generalization of the General Theory. Macmillan, London.
18. World Bank. (2012). Benchmarking Financial Systems around the World. *Policy Research Working Paper, WPS6175*.
19. World Bank. (2019, July 1). Gross domestic product, 2018. *World Development Indicators database*.

МУЗЕЙН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

П.Баасанжаргал^{1*}, Л.Оюунцэцэг², Ж.Эрхэмтөгс³

¹Соёл урлагийн их сургууль

²Шинжлэх ухаан технологийн их сургууль

³Соёл урлагийн их сургууль

Хураангуй

Соёл урлагийн салбарын нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмэр жилээс жилд өсч, зарим улс орнуудын хувьд эдийн засгийн тэргүүлэх чиглэл болон хөгжиж байна. Манай улсын соёлын салбарын хөгжлийн өнөөгийн байдал дэлхийн улс орнуудтай харьцуулахад доогуур байгаа бөгөөд салбарын хөгжилд тулгамдаж буй гол асуудлын нэг нь маркетингийн хэрэгжүүлэлт муу, салбарын маркетингийн хоцрогдмол байдал юм. Соёлын салбарын маркетингийг хөгжүүлэхэд юун түрүүнд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, үйлчлүүлэгчдэд санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээ үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг тодорхойлж, судалгааны үр дүнд тулгуурлан үр ашигтай маркетинг хэрэгжүүлэх нь нэн чухал. Музей нь соёл урлагийн салбарын зах зээлд чухал байр суурийг эзэлдэг дэд салбар бөгөөд хүн амын урлагийн боловсрол, улс орны соёлын хөгжлийн түвшинг тодорхойлогч хүчин зүйлсийн нэг мөн. Музейн үйлчилгээний чанар, хүртээмж, үр өгөөжийг сайжруулах асуудал салбарын өмнө тулгамдаж буй асуудлын нэг юм. Иймээс музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг олон улсад туршигдсан судалгааны арга зүй болох А.Parasuraman, V.A Zeithaml, L.L.Berry нарын боловсруулсан SERVQUAL загварыг(5 бүлэг 22 хэмжүүр) ашиглан, үндэсний хэмжээнд 899 респондентоос асуулгын аргаар судалгаа авч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн өнөөгийн байдлыг тодорхойлохыг зорисон.

Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн ерөнхий үнэлгээ 3.48 буюу “дунд” гэсэн үнэлгээтэй, бусад дэд салбаруудаас хамгийн доогуур байгаа нь цаашид музей бүр үйлчилгээний чанараа сайжруулахад анхаарах хэрэгтэй байгааг харуулж байна.

Түлхүүр үг: музей, хэрэглэгчийн сэтгэл ханамж, соёл урлагийн байгууллага, үйлчилгээний чанар, соёл урлагийн маркетинг

1. УДИРТГАЛ

Соёл урлаг нь аливаа улс, үндэстний нийгмийн хөгжил дэвшлийг тодорхойлогч хүчин зүйлсийн нэг мөн. Соёл урлагийн салбарын нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмэр жилээс жилд өсч, зарим улс орнуудын хувьд эдийн засгийн тэргүүлэх чиглэл болон хөгжиж байгааг АНУ, Их Британи, Тайван, БНСУ, Сингапур, Хонгконг, Европын орнуудын жишээнээс харж болно. Дэлхийн урлагийн зах зээлийн борлуулалт 2018 оны байдлаар 67,4 тэр бум ам.долларт хүрсэн нь өмнөх оны борлуулалтаас 6%-иар өссөн байна. Дэлхийн урлагийн зах зээлийг дийлэнх буюу 84%-ийг АНУ(44%), БНХАУ(21%), Их Британи(19%) гэсэн гурван улс бүрдүүлж байгаа бөгөөд нийт 2,7 сая хүн ажиллаж, 296540 байгууллага энэ салбарт үйл ажиллагаа явуулж байна⁶.

Манай улсын соёл урлагийн салбар 2018 оны байдлаар ДНБ-ий 0.4 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд 903 байгууллага (*аж ахуй нэгжийн 1.05%*) үйл ажиллагаа явуулж, 7041 ажиллагчид (*нийт ажиллах хүчний 0.56%*) 12,351,000 үйлчлүүлэгчдэд соёл урлагийн үзвэр, үйлчилгээг хүргэсэн байна⁷.

Музей нь нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэхүйц олон нийтэд зориулагдсан, байнгын үйл ажиллагаатай, ашгийн төлөө бус

байгууллага бөгөөд хүний түүх, амьдрах орчны тухай баримт гэрч болох эд зүйлийг судлах, хүнийг гэгээрүүлэх оюуны хэрэгцээг нь хангах зорилгоор олж цуглуулах, хадгалах, хамгаалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлж сурталчлах ажил эрхэлдэг газар юм. Музей нь улс орны соёлын хөгжлийн түвшинг тодорхойлогч хүчин зүйлийн нэг бөгөөд салбарын зах зээлд чухал байр суурийг эзэлдэг дэд салбарын нэг мөн.

2018 оны байдлаар Монгол Улсад нийт 46 музей үйл ажиллагаа явуулж байгаагаас хөдөө орон нутагт 25 (54.3%), Улаанбаатар хотод 21 (45.7%) музей үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс орон нутгийн 25, төрийн өмчийн 12, хувийн хэвшлийн 9 музей үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 46 музейд 289.6 мянган ширхэг үзмэр хадгалагдаж, жилдээ 781.4 мянган хүн үйлчлүүлсэн байна.

Музейд төдийгүй соёл урлагийн салбарын хөгжилд тулгамдаж буй гол асуудлуудад 1)маркетингийн хэрэгжүүлэлт муу, энэ талын ойлголт төлөвшөөгүй, 2)салбарын судалгаа хөгжүүлэлт сул, 3) хууль эрх зүйн орчин тааруу, 4) мэргэшсэн хүний нөөц хангалтгүй, мэргэжлийн ур чадвар сул, 5) орчин, нөхцөл тааруу гэсэн асуудлууд ордог.⁸ Эндээс салбарын хөгжлийг эрчимжүүлэх, түүний

⁶ Art Basel, Sales in global art market-2018 report

⁷ МУҮСХ, Салбарын танилцуулга-2018

⁸ Эрхэмтөгс Ж. Монгол улсад соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга зам, 2016

нийгэм, эдийн засгийн өгөөжийн дээшлүүлэхэд маркетингийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол маш чухал болох нь харагдаж байна. Үр ашигтай маркетингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, оновчтой маркетингийн шийдвэр гаргахад хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа чухал үүрэгтэй.

Манай улсын соёл урлагийн ихэнх байгууллагууд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийдэггүй, судалгааны үр дүнд тулгуурлан маркетингийн шийдвэр гаргах байдал дутмаг байна⁹. Иймд соёлын салбарын судлаачид, маркетерууд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд онцгой анхаарч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид нөлөөлөгч хүчин зүйлсийг нарийвчлан судлаж, судалгааны үр дүн тулгууран маркетингийн шийдвэр гаргах нь салбарын хөгжилд нэн чухал.

2. ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ, ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ОНОЛЫН ТОЙМ

Дэлхий дахинд зах зээлд нийлүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээ төдийгүй бүхий л салбаруудад хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээний асуудалд

ихээхэн анхаарал хандуулдаг¹⁰. Зарим улсын засгийн газраас бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий чанарыг үнэлэх зорилгоор хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индекс(CSI)-ийг тогтмол үнэлж, судалгааны үр дүнг байгууллага болон олон нийтэд түгээдэг байна.

Дэлхийд анх удаа хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индекс(CSI)-ийн загварыг боловсруулсан улс бол Швед улс бөгөөд 1989 онд Шведийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн барометр(SCSB)-ыг боловсруулж, нэвтрүүлсэн байна. 1994 онд Америкийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индекс(ACSI)-г АНУ, 1999 онд Европын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индекс (ECSI)-ийг Европын холбооны 11 улс, 2015 онд Хятадын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индекс(CCSI)-ийг БНХАУ нэвтрүүлсэн бол Герман, Шинэ Зеланд, Норвеги, БНСУ-ууд тус тус хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индекс(CSI)-ийг боловсруулан хэрэгжүүлж байна. Харин Монгол улсын хувьд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн индексийг хараахан боловсруулаагүй байна.

Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн талаар 1970 аад оноос хойш олон эрдэмтэн судлаачид судалсаар иржээ. Swan, Trawick болон Carroll нар

⁹ Баасанжаргал П, Оюунцэцэг Л. Соёлын бүтээлч үйлдвэрлэлд маркетингийн гүйцэтгэх үүрэг, 2019

¹⁰ Yan Wang*, Jingjing Han and Songzhu Zheng, Measure audiences' satisfaction through user generated content-satisfaction research in motion picture industry

1980 онд “Хэрэглэгчид тухайн бүтээгдэхүүнийг хэрэглээний явцад болон дараа нь чанартай, чанаргүй эсвэл хэрэглэхэд тохиромжтой ба тохиромжгүй байдлаар нь үнэлсэн үнэлгээг сэтгэл ханамж” гэж тодорхойлсон байна. Үүний дараагаар 1981 онд судлаач Oliver сэтгэл ханамжийг тодорхойлохдоо “Хэрэглэгчийн тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт болон худалдан авсны дараах бодит байдал хоёрын зөрүү” юм. Бодит байдал хүлээлтээс илүү буюу тэнцүү бол хэрэглэгч сэтгэл хангалуун, эсрэг тохиолдолд сэтгэл хангалуун бус байдаг хэмээжээ. Үүнтэй адилаар 1988 онд Tse, Wilton нар “Тухайн бүтээгдэхүүний анхны хүлээлт болон хэрэглэсний дараах бодит гүйцэтгэл хооронд мэдэрсэн зөрүүнд үнэлгээ өгөх хэрэглэгчийн хариу үйлдлийг сэтгэл ханамж” хэмээн тодорхойлжээ. Мөн 1996 онд Bitner болон Zeithmall нар “Сэтгэл ханамж бол хүлээлт гүйцэтгэл хоёрын нийцэж байгаа эсэхэд өгч буй хэрэглэгчийн үнэлгээ юм” хэмээн дүгнэжээ (Giese & Cote, 2000). Үүнээс үзэхэд олон судлаачид хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг тухайн бүтээгдэхүүн үйлчилгээнээс бий болсон хүлээлт болон бодит байдалтай хамааруулж тодорхойлсон байна.

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх олон арга, загварууд байдгаас олон салбарт туршигдсан,

хамгийн түгээмэл хэрэглэгддэг загвар нь үйлчилгээний чанар, хэрэглэгчийн сэтгэл ханамж, улмаар хэрэглэгчийн хүлээлт, чадвар, туршлагын ялгааг тодорхойлдог A.Parasuraman, V.A Zeithaml, L.L.Berry нарын боловсруулсан SERVQUAL буюу PZB загвар (1985) юм¹¹. Тэд SERVQUAL загварын энхний хувилбарыг боловсруулахын тулд бүлгийн ярилцлага явуулж үйлчлүүлэгчийн үнэлэлт дүгнэлтэд тулгуурлан адил төстэй шалгуурыг тогтоосноор үйлчилгээний чанарын арван хэмжүүрийг гаргасан. Үйлчилгээний чанарын арван хэмжүүрт мэдрэгдэж анзаарагдахуйц байдал, найдвартай байдал, уриалгахан байдал, чадвар чадамж, хүрэх боломж, эелдэг зан, харилцан ойлголцол, итгэл даах байдал, аюулгүй байдал, ойлголцол орно. Энэ судалгаанд үйлчилгээний энэ арван хэмжээс давхцаж болох бөгөөд тэд цаашид судалгаа явуулах шаардлагатай гэж үзсэн. Иймээс SERVQUAL загварыг боловсронгуй болгож, шинэчлэн, өөрчилсөн хувилбарын боловсруулсан. 1988 онд A.Parasuraman, V.A Zeithaml, L.L.Berry нар уг арван хэмжүүрийг үндсэн бүтэц болгон ашиглаж үйлчлүүлэгчдийн үйлчилгээний чанарыг ойлгож хүлээн авах байдлыг хэмжих эмпирик судалгаа явуулсан. Уг судалгааны үр дүнд

¹¹ Michael S.Minor, Tillman Wager, F.T.Brewerton and Angela Hausman. Rock on! An elementary model of customer satisfaction with musical performance, 2004

энэ арван хэмжүүрийн зарим нь хувьсагч нь хоорондоо давхцаж байгаа нь харагдсан. Эдгээр арван хувьсагчаас мэдрэгдэж анзаарагдах байдал, итгэл даах байдал, уриалгахан байдал гэсэн хувьсагчууд хэвээр үлдэж, бусад долоон хувьсагчийг баталгаа ба бусдыг ойлгох гэсэн хувьсагчуудад ангилан оруулсан. Үүний үр дүнд 5 үндсэн хэмжүүр бүхий 22 нэгж үзүүлэлт бүхий SERVQUAL загварыг шинэчлэн боловсруулсан. Шинэчлэн боловсруулсан энэ хувилбарт үйлчилгээний чанарыг дараах таван үндсэн хэмжүүрүүд орно. Үүнд:

- **Tangibles** буюу биет байдал-хүртэгдэх байдал. Байгууллагын бодит орчны мэдрэгдэх байдлыг харуулах бөгөөд барилга байгууламж, ашиглаж байгаа тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ажиллагчдын хувцаслалт өнгө үзэмж, гадаад төрхтэй холбоотой үзүүлэлтүүд .
- **Reliability** буюу итгэл үнэмшил, найдвартай байдал. Ажиллагчдын байгууллагын болон үйлчилгээний талаарх мэдлэг, санал болгож буй үйлчилгээгээ зохиох ёсоор үзүүлэх байдал, үйлчлүүлэгчидтэй харилцах харьцаа, итгэл төрүүлэх байдал.
- **Responsiveness** буюу үүрэг хариуцлага, хариу үйлдэл. Үйлчлүүлэгчиддээ туслах чин эрмэлзэл, үйлчлүүлэгчдэд тулгарсан асуудлыг шийдэхэд уриалгаханаар туслахад байдал.
- **Assurance** буюу баталгаатай байдал. Ажиллагчдын эзэмшсэн мэдлэг, ур чадвар, өрсөлдөхүйц байдал, аюулгүй байдал, үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах байдал.
- **Empathy** буюу шуурхай байдал, анхаарал халамж. Үйлчилгээний хялбар байдал, харилцаа холбоо, хэрэглэгчдээ ойлгох, үйлчлүүлэгч бүрд анхаарал тавих, үйлчлүүлэгчдийн онцлог, онцгой хэрэгцээг мэдэрч анхаарал хандуулах.

3. МУЗЕЙН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙ, АРГАЧИЛАЛ

A.Parasuraman, V.A Zeithaml, L.L.Berry нарын боловсруулсан SERVQUAL загварыг олон салбарт, төрөл бүрийн үйлчилгээний чанарыг хэмжихэд өргөн хэрэглэдэг болохыг олон судалгааны үр дүнгээс харж болно. Харин соёл урлагийн салбарт хийсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны ажлууд бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй цөөн, соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох хувьсагчуудын талаар судалгааны мэдээлэл тун ховор байна. Соёлын салбараас аялал жуулчлал, хөгжим, номын сан, музейн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа цөөн тоогоор хийгдсэн байна.

Соёл урлагийн салбарт нилээд хожуу буюу 1970-аад оноос урлагийн байгууллагууд зохион байгуулж буй арга хэмжээг хэрэглэгчдэд мэдээлэх байдлаар маркетингийн ухааныг хэрэглэж эхэлсэн гэж үздэг¹². Өнөөг хүртэл соёл урлагийн маркетинг нь соёлын өөрчлөлт, техник технологийн хувьсал, глобалчилал, зах зээлийн өрсөлдөөн зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөгөөр дээдсийн урлаг (high art)-аас нийтийн соёлруу (popular culture), ашгийн бус концепцоос зах зээлийн чиг хандлагаруу (marketisation), бүтээгдэхүүний чиг хандлагаас (product-led) зах зээлийн чиг хандлагаруу (market-led) шилжин, хөгжиж байна¹³.

Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар хийсэн судалгааны үр дүнгээс харахад соёлын бүтээгдэхүүний маркетингийн иж бүрдэл нь нийлмэл шинжтэй, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, хүлээлтээс гадна уран бүтээлчийн үзэл санаа, онцлог үйлчилгээний чанарт нөлөөлдөг. (Kotler and Levy, 1969; Levi and Czepiel, 1975; Mokwa, Dawson and Prieve, 1980; Colbert, 2000)

Судлаач Michael S.Minor нар SERVQUAL загварыг ашиглан хөгжмийн хэрэглэгчийн

¹² Botita M.Kolb, *Marketing for Cultural Organisations*, 2005

¹³ Hye-Kyug Lee, *When arts met marketing: Arts marketing theory embedded in romanticism*, 2005

сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааны ажлын хүрээнд дөрвөн үндсэн хэмжүүр бүхий хөгжмийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн тодорхойлох загварыг онол арга зүйн үндэс болгосон байна. Энэхүү загварт 1) суудал-суудал хоорондын зай, тохь тух, суудлын байршил-тоглолт харагдах байдал, 2) уран бүтээлч-уран бүтээлчийн мэргэжлийн ур чадвар, үзэгчдэд танигдсан байдал, хувийн зан чанар, гадаад төрх, сэтгэл татам байдал, нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, хувцаслалт, харагдах байдал, 3) уран бүтээлч-уран бүтээлийн чанарт үзүүлэх хүний хүний хүчин зүйлс, хөгжмийн дуугаралт, тоглох хэлбэр, 4) хэрэглэгч/үйлчлүүлэгч-үйлчлүүлэгчийн туршлага, үйлчлүүлэгчдийн тооноос хамаарсан үйлчлүүлэгч хоорондын зай, тухайн үзэгчийн болон бусад үзэгчийн туршлага, уран бүтээлийн талаарх эерэг болон сөрөг мэдрэмж, үзэл бодлоо хуваалцах байдал, үзэгчийн сонирхол, уран бүтээлийг хүлээж авах байдал гэсэн дөрвөн хэмжүүрийн дагуу судалгааны асуулгаа боловсруулж, лайкертийн 5 шкалаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийг үнэлсэн байна.

Манай улсын олон салбаруудын эрдэмтэн судлаачид, маркетерууд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хийж, судалгааны үр дүнг шийдвэр гаргалтад өргөн ашиглаж байна. Харин соёл урлагийн салбарын хувьд соёл

урлагийн зах зээлийн судалгаа, хэрэглэгчийн судалгаа(хөгжмийн, театрын, музейн, соёл чөлөөт цагийн үйлчилгээ, сонгодог урлаг, кино урлаг..гэх мэт), хэрэглэгчийн зан төлөвийн судалгааг цөөн тооны эрдэмтэн судлаачид, маркетерууд хийсэн хэдий ч үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг SERVQUAL загварыг ашиглан үнэлсэн судалгаа байхгүй байна.

Соёл урлагийн салбарын зах зээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны онол арга зүй болон музейн үйлчлүүлэгчийн сэтгэл

ханамжийн судалгаануудад ашигласан арга зүй, сэтгэл ханамжийг тодорхойлох хувьсагчуудыг харьцуулан судалсны үндсэн дээр энэхүү судалгааны арга зүйг дараах байдлаар боловсруулав.

Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлэхдээ A.Parasuraman, V.A Zeithaml, L.L.Berry нарын боловсруулсан SERVQUAL загварын дагуу 5 бүлэг 22 хувьсагчийн дагуу Лайкертийн шкалаар (1 оноо - маш муу, 2 оноо - муу, 3 оноо - дунд, 4 оноо - сайн, 5 оноо - маш сайн) үнэлсэн. Үүнд:

Хүснэгт 1. Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх хувьсагч

Хэмжүүр		Урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг тодорхойлох хувьсагчууд
Биет байдал	1	Орчин үеийн, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж ашиглах байдал
	2	Дотоод орчны тохижилт (үзвэр/үйлчилгээний заалны суудал, гэрэлтүүлэг, агааржуулалт, тасалгааны температур, акустик)
	3	Хувцасны өлгүүр, ариун цэврийн өрөөг шийдсэн байдал
	4	Гадаад орчны тохижилт (авто машины зогсоол, гэрэлтүүлэг, гадаад тохижилт)
	5	Хувцаслалт, имиж бүрдүүлэлт (уран бүтээлчийн хувцаслалт, имиж, ажиллагчдын хувцаслалт)
Үүрэг хариуцлага	6	Үйлчлүүлэгчдийн гомдлыг цаг тухайд нь шийдэх байдал
	7	Үйлчлүүлэгчдэд амласан амлалтаа биелүүлэх байдал
	8	Үйлчлүүлэгчдийн хүсэлтийг сонсож, шийдвэрлэх байдал
	9	Үйлчилгээний ажиллагчдын харилцааны соёл, ёс зүй
	10	Үйлчлүүлэгчидтэй чин сэтгэлээсээ, эелдэг харилцах байдал
Итгэл үнэмшил	11	Үзвэр/үйлчилгээний талаарх мэдээллийг оновчтой сувгаар бүрэн хүргэх байдал
	12	Үйлчлүүлэгчийн асуултад бүрэн хариулах мэдлэг, ур чадвар
	13	Нэмэлт үйлчилгээг шийдсэн байдал (буфет, хоолны газар, кофе шоп, дэлгүүр....)
	14	Мэргэжлийн ур чадвар(уран бүтээлчдийн болон бусад ажиллагчдын)

Анхаарал халамж	15	Үйлчлүүлэгчийн тусгай хэрэгцээнд анхаарал хандуулах байдал (<i>хөгжлийн бэрхиээлтэй иргэд, онцгой хэрэгцээ шаардлага</i>)
	16	Байгууллагийн ажиллах цагийн хуваарийн тохиромжтой байдал
	17	Үйлчилгээний цагийн хуваариа мөрдөж ажиллах байдал
	18	Үзвэр/үйлчилгээний билет захиалгыг шийдсэн байдал
Багалгаатай байдал	19	Шинэ үзвэр/үйлчилгээг нэвтрүүлэх байдал
	20	Үзвэр/үйлчилгээний сонголт, нэр төрөл, хүртээмж
	21	Үзвэр/үйлчилгээний чанар үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээтэй нийцэх байдал
	22	Үзвэр үйлчилгээний үнэ үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээтэй нийцэх байдал

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

4. МУЗЕЙН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1. Судалгааны ажлын зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь музейн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн өнөөгийн байдлыг тодорхойлоход оршино.

Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн хэмжээнд нийт 899 респондентоос 5 бүлэг 22 хувьсагч бүхий анкет асуулгын аргаар тодорхойлсон. (Likert scale: 1- маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн)

Асуулгын судалгааны түүврийн хэмжээг музейн үйлчлүүлэгчдээс санамсаргүй түүврийн аргаар сонгон авч судалгаанд хамруулсан. Энгийн санамсаргүй үүвэр буюу нийт олонлогоос судалгаанд хамруулах респондентийг тэнцүү магадлалтайгаар сонгосон тул түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцсон.

$$n = \frac{t^2 * p * (1 - p) * N}{e^2 * N + t^2 * p * (1 - p)}$$

Энд:

n - түүврийн хэмжээ

t - итгэх түвшин (95%-ийн итгэх түвшинд $t = 1.96$)

p = нийт хүн амд эзлэх соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчид

N - эх олонлогийн тоо

E - түүврийн алдааны хязгаар

Түүврийн эх олонлогийг Монгол улсын 15 ба түүнээс дээш насны 2336427 иргэдээр, алдааны хязгаарыг 2,5%, итгэх магадлалыг 95% байхаар тооцсон. Хүн амын бусад бүлэгтэй харьцуулахад эдгээр хүмүүс нь судалгаанд илүү бодитой мэдээлэл өгдөгийг үндэс болгов¹⁴. Асуулгын судалгааны өгөгдлийг судалгааны өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд өргөн хэрэглэгддэг SPSS-24 программд боловсруулж, холбогдон тоон болон чанарын шинжилгээг хийв.


¹⁴ БСШУЯ, УА, Засгийн газраас боловсрол, соёл, шинжлэх ухааны талаар баримталж буй бодлого, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх хэрэглэгчдийн үнэлгээ, судалгаа, 2011

4.2. Судалгаанд оролцогчдын талаарх мэдээлэл

Музейн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг нэгдсэн судалгааны арга зүй, аргачлалын дагуу 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргээс нийт 899 респондентээс судалгаа авч судалгааны үр дүнг дор харуулав. Судалгаанд оролцогчдын талаарх мэдээллийг нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн байдал, өрхийн ам бүлийн тоо болон 1 сарын дундаж

орлого, оршин сууж буй газрын харьяалал гэсэн үзүүлэлтүүдээр авч судалсан. Судалгаанд оролцогчид нь хүйсийн хувьд 58.1%% нь эмэгтэй, 41.9% нь эрэгтэй респондент байсан бол насны бүтцийн хувьд дийлэнх нь буюу 30% нь 24-35 насныхан, 22.8%% нь 36-45 насныхан, 17.3% нь 19-23 насны иргэд хамрагдсан байна.


Зураг 1. Судалгаанд оролцогчдын насны бүтэц, хүйс



Эзэмшсэн боловсролын түвшинг авч үзвэл судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 56.4% нь дээд, 16.3% нь мэргэжлийн боловсролтой

гэж хариулсан бол 25.6% нь дунд, 1.8% нь бага боловсролтой иргэд оролцсон байна.

Зураг 2. Судалгаанд оролцогчдын эзэмшсэн боловсрол, ажил эрхлэлтийн байдал



Харин ажил эрхлэлтийн хувьд 27.3% нь төрийн болон төсвийн байгууллагад, 24.6 % нь хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг, 14 % нь оюутан, 7.3 % нь 7.3% нь ажил бизнес эрхлэгчид, 2,8% нь мал аж ахуй эрхлэгчид хамрагдсан

нь түүврийн зохистой хэмжээг хангасан иргэд судалгаанд оролцсныг харуулж байна. (Зураг 2)

Судалгаанд оролцогчид ам бүлийн тооны хувьд дийлэнх нь 3-4 ам бүлтэй гэж хариулжээ.


Зураг 3. Өрхийн ам бүлийн тоо болон өрхийн сарын дундаж орлого (төгрөг)



Өрхийн 1 сарын дундаж орлогын хувьд 23.3% нь 500,001-800,000₮, 20.2% нь 800,001-1,200,000₮, 12% нь 1,200,000-1,500,000₮ орлоготой гэж хариулсан бол 8 % нь 2,500,000₮-өөс дээш орлоготой, 12% нь 320,001-500,000₮, 8.9% нь 320,000 хүртэлх төгрөгний орлоготой иргэд хамрагдсан байна.

Оршин сууж харьяаллын хувьд хөдөө орон нутгаас 437, Улаанбаатар хотоос 462 респондент судалгаанд оролцсон бөгөөд аймаг, дүүргүүдээс оролцсон респондентуудын тооны харьцаа түүврийн зохистой хэмжээг хангасан байгаа нь зураг 4-өөс харагдаж байна.

Зураг 4. Судалгаанд оролцогчдын оршин суугаа газрын харьяалал



Судалгаанд оролцогчдын талаарх дээрх мэдээллийг статистик мэдээлэл болон түүврийн

тооцоололтой харьцуулан дүгнэхэд эдгээр респондентууд түүврийн зохистой хэмжээг хангаж байна.

4.3. Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ

Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэхээр сонгон авсан 5 бүлэг 22 хувьсагчийн дундаж үнэлгээг Chronbach's Alpha коэффициентоор найдвартай байдлын шинжилгээ хийж үзэхэд

$\alpha=0.901$ буюу 0,7-оос их гарсан нь эдгээр хувьсагчид ач холбогдолтой болохыг харуулж байна. Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээрх арга зүйн дагуу үнэлж, судалгааны үр дүнг дор харуулав.

Хүснэгт 2. Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ


	Сэтгэл ханамжийг тодорхойлогч хүчин зүйлс	Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ
1	Орчин үеийн, дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж ашиглах байдал	3.59
2	Үйлчилгээний цагийн хуваариа мөрдөж ажиллах байдал	3.58
3	Ажиллагчдын мэргэжлийн ур чадвар	3.58
4	Үйлчлүүлэгчийн асуултад бүрэн хариулах мэдлэг, ур чадвар	3.58
5	Үйлчилгээний ажиллагчдын харилцааны соёл, ёс зүй	3.57
6	Үйлчлүүлэгчидтэй чин сэтгэлээсээ, эелдэг харилцах байдал	3.57
7	Байгууллагийн ажиллах цагийн хуваарийн тохиромжтой байдал	3.56
8	Дотоод орчны тохижилт (үзвэр/үйлчилгээний заалны суудал, гэрэлтүүлэг, агааржуулалт, тасалгааны температур, акустик)	3.55
9	Үзвэр/үйлчилгээний талаарх мэдээллийг оновчтой хүргэх байдал	3.55
10	Үйлчлүүлэгчдэд амласан амлалтаа биелүүлэх байдал	3.53
11	Үзвэр үйлчилгээний үнэ үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээтэй нийцэх байдал	3.52
12	Үйлчлүүлэгчдийн хүсэлтийг сонсож, шийдвэрлэх байдал	3.51
13	Үзэгчийн/үйлчлүүлэгчдийн боловсролд анхаарах байдал	3.49
14	Үйлчлүүлэгчдийн гомдлыг цаг тухайд нь шийдэх байдал	3.47
15	Үзвэр/үйлчилгээний билет захиалгыг шийдсэн байдал	3.47
16	Үзвэр/үйлчилгээний сонголт, нэр төрөл, хүртээмж	3.46
17	Ажиллагчдын хувцаслалт, имиж бүрдүүлэлт	3.44
18	Шинэ үзвэр/үйлчилгээг нэвтрүүлэх байдал	3.43
19	Үзвэр/үйлчилгээний чанар үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээтэй нийцэх байдал	3.43

20	Үйлчлүүлэгчийн тусгай хэрэгцээнд анхаарал хандуулах байдал (хөгжлийн бэрхшээлтэй иргэд, онцгой хэрэгцээ шаардлага)	3.40
21	Хувцасны өлгүүр, ариун цэврийн өрөөг шийдсэн байдал	3.35
22	Гадаад орчны тохижилт (авто машины зогсоол, гэрэлтүүлэг, гадаад тохижилт)	3.34
23	Нэмэлт үйлчилгээг шийдсэн байдал (буфет, хоолны газар, кофе шоп, дэлгүүр....)	3.18
Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн дундаж үзүүлэлт		3.48

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогчид музейн үйлчилгээнд 3,48 буюу “дунд” гэсэн үнэлгээ өгсөн байна. Эндээс нэмэлт болон дагалдах үйлчилгээ, гадаад болон дотоод орчны тохижилт, үзвэр үйлчилгээний сонголт нэр төрөл, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх байдал гэсэн үзүүлэлтүүд хамгийн доогуур байгаа бол

ажиллагчдын мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний ажиллагчдын харилцаа, үйлчилгээний үзүүлэх байдал харьцангуй өндөр гарсан байна.

Тэгвэл музейн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин судалгаанд оролцогчдын оршин сууж буй дүүрэг, аймгуудаас хамаарч ялгаатай байгаа эсэхийг тодруулахад:



Сэлэнгэ, Баянхонгор, Завхан аймгуудын музейн сэтгэл ханамжийн үнэлгээ 4,0-оос дээш буюу “сайн” гэж үнэлэгдсэн бол Архангай, Орхон, Өвөрхангай аймгуудын музейн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ маш доогуур буюу “муу” гэж үнэлэгдсэн байна. Музейн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин төвийн

бүсд хамгийн өндөр буюу 3,63 байхад хангайн бүсэд хамгийн доогуур буюу 3,31 гэсэн дундаж үнэлгээтэй байна.

Судалгаанд оролцогчидоос музейгээр үйлчлүүлэх зорилго, шалтгааныг тодруулахад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

Зураг 5. Музейгээр үйлчлүүлэх зорилго



Музейгээр үйлчүүлэгчид ихэвчлэн танин мэдэх, шинэ мэдлэг олж авах (42,6%), чөлөөт цагаа өнгөрөөх (42,1%), гэр бүл, дотны хүмүүстэйгээ цагийг хамт өнгөрөөх (27.6%), урлагийн боловсролоо дээшлүүлэхх (26,4%), хүүхдээ хөгжүүлэхэд анхаарах (24.4%), аялалыг хөтөлбөрт багтсан учир (19.5%), судалгаа шинжилгээний ажил хийх (19.5%) зорилгоор музейгээр үйлчлүүлдэг байна.

Аль бүс нутагт орших ямар музейгээр иргэд хэрхэн үйлчлүүлдэгийг тодруулахад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна. Үүнд:

Музейгээр үйлчлүүлэгчдийн дийлэнх нь Үлэг гүрвэлийн музей (38.1%), Байгалийн түүхийн музей (33.1%), Монголын үндэсний музей (22,2%), Богд хааны ордон музей (21.8%), аймгуудын музей (21,2%) музейгээр үйлчлүүлдэг байна. Сүүлийн жилүүдэд Чойжин ламын сүм музей, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагийн музей

шинэ үйлчилгээ, сонирхолтой арга хэмжээг зохион байгуулах болсон нь үйлчүүлэгчийн сонирхлын татаж, бүх насны үйлчлүүлэгчдийн музейгээр үйлчлүүлэх сонирхол нэмэгдэж байна.

Цаашид музейгээс хүсч буй бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.

Музейн үйлчлүүлэгчдийн хамгийн их хүсч буй үйлчилгээ нь шинэ, сонирхолтой үзмэрийг нэмэгдүүлэх(54.4%), хүүхдэд болон насанд хүрэгчдэд зориулсан шинэ үйлчилгээ(33,2%), чөлөөт цагт зориулсан үйлчилгээ(33%), музейн талаарх мэдээлэл сурталчилгаа(32,7%) гэж хариулсан байна.

5. ДҮГНЭЛТ

Музейн үйлчүүлэгчийн сэтгэл ханамжийн өнөөгийн байдлыг тодорхойлохыг зорисон энэхүү судалгааны онол арга зүйг

A.Parasuraman, V.A Zeithaml, L.L.Berry нарын боловсруулсан SERVQUAL (1988) загварт тулгуурлан, 5 бүлэг 22 хувьсагчийг сонгон авч музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг Лайкетрын 5 шкалаар үнэлсэн.

Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.48 буюу “дунд” гэсэн үнэлгээтэй, соёл урлагийн бусад дэд салбаруудтай харьцуулахад хамгийн доогуур үнэлгээтэй байна. (*театр, чуулга-3.49, соёлын төв, ордон-3,59, номын сан-3,7*) Энэ нь цаашид музей бүр үйлчилгээний чанараа сайжруулахад чиглэсэн маркетинг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Цаашид музейн үйлчилгээг сайжруулахад:

1. М э р г э ж л и й н , ч а д в а р л а г маркетерээр хүний нөөцөө бүрдүүлэх/одоогийн менежерээ чадавхижуулах, зах зээлийн чиг хандлага-хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг судлаж, судалгааны үр дүнд тулгуурлан үр ашигтай маркетинг хэрэгжүүлэх,
2. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, шинэлэг үзмэр болон дагалдах үйлчилгээг хөгжүүлэх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх,
3. Гадаад болон дотоод орчины тохижилтыг сайжруулах, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх,
4. Ивээн тэтгэлэг-сан бүрдүүлэлтийн чиглэлээр хувь хүн болон албан байгууллагуудтай хамтран ажиллах,
5. Үйлчлүүлэгчдийн чөлөөт цагаа өнгөрөөх шинэлэг орчин, гэр бүлд зориулсан шинэ-бүтээлч үйлчилгээг хөгжүүлэх хэрэгтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Art Basel, Sales in global art market-2019
2. Botita M.Kolb, Marketing for Cultural Organisations, 2005
3. Chris Ryan, Museums, exhibits and visitor satisfaction: a study of the Cham Museum, Danang, Vietnam, 2013
4. Hye-Kyug Lee, When arts met marketing; Arts marketing theory embedded in romantism, 2005
5. Manual Cuadrado-Garcia, Carmen Periz-Cabanero, Juan D.Montoro-Pons. Managing satisfaction in cultural events, 2017
6. Margee Hume and Gillian Sullivan Mort, Satisfaction in performing arts: the role of value?, 2015
7. Michael S.Minor, Tillman Wager, F.T.Brewerton and Angela Hausman. Rock on! An elementary model of customer satisfaction with musical performance, 2004
8. Shi, Hui-Ying Study of Service Quality and Satisfaction for Museums: Taking the National Museum of Prehistory as an Example, 2008
9. A.Parasuraman, V.A Zeithaml, L.L.Berry, SERVQUAL: a multiple-item scale for measuring consumer
10. Yan Wang*, Jingjing Han and Songzhu Zheng, Measure audiences' satisfaction through user generated content-satisfaction research in motion picture industry
11. Баасанжаргал П, Оюунцэцэг Л. Соёлын бүтээлч үйлдвэрлэлд маркетингийн гүйцэтгэх үүрэг, 2019
12. Баасанжаргал П, Оюунцэцэг Л. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн маркетингийн стратегийн асуудал, 2019
13. Урантуяа М. ЕБС-уудын үйлчилгээний чанарыг SERVQUAL аргаар үнэлэх арга зүй//Менежмент ба инноваци эрдэм шинжилгээний сэтгүүл.-УБ., 2018-№4.-Х86-91.
14. Эрхэмтөгс Ж. Монгол улсад соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга зам. Бизнесийн удирдлагын ухааны докторын(Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл.-УБ.,2016.-Х53-74
15. МУҮСХ, Салбарын танилцуулга-2018

Article info: Mandakh Research, 2020, BUS 304, Vol.03, 36-45

THE FACTORS AFFECTING LIFE EXPECTANCY IN MONGOLIA

Munkhtsetseg Sandagsuren^{1, a*}, Tsagaankhvv Purewdorj^{2, b}

¹The Economics and Business Department of Mandakh University

²Accounting-English 4th class of Mandakh University

^as_munkhtsetseg@mandakh.mn, ^bptsng11@gmail.com

Abstract

The life expectancy is essential indicator to identify the country's development, happy planet index, human development index, quality of life index etc. Studying on life expectancy is important for the policy makers to find the optimum way to increasing people's life expectancy. This research work is important for the experts to figure out the approach that increase the life expectancy. Although it is such important index and this kind of study is common in the worldwide, there is no research work in our country. Thus, we aim to identify factors that affect life expectancy in Mongolia using ordinary least squares regression analysis. Life expectancy is the dependent variable with, GDP per capita health expenditure per capita, and urbanization as the 2 main determinants. This is a time series study collecting annual data from World Open Source database 2000 to 2017. The result shows that health expenditure per capita and urbanization are influencing life expectancy positively.

Keyword: GDP per capita, Health expenditure per capita, Urbanization, Air pollution, Education

1. INTRODUCTION

The study of life expectancy is essential topic of medical and socioeconomic sector in any country. Life expectancy, often explained to Life expectancy at birth is a statistical measure of the average that expected to live, based on the year of its birth, its current age and other demographic factors including gender. In the worldwide, life expectancy has been increasing steadily over the past few decades, due to technology, medication, and economy. In the case of Mongolia, life expectancy has increased by 3-4 years over the last decade. The life expectancy still different between developed and developing countries. It related with the reason that the increases in life expectancy depends on improvements in sanitation and access to pure water, access to health care, including vaccines and enormous increases in agricultural development. Therefore, life expectancy research often focuses on income inequality, economic growth, and health expenditure.

The average life expectancy of our population is 70.19, which is listed 131th place in the world. (United Nations, 2019) It means that life expectancy in Mongolia is lower than in other countries. Accordingly, our country needs to take measures to increase the life expectancy of the population. In order to do this, we need to identify the factors that increase and decrease life expectancy.

So we considered that this research work is important for the experts to figure out the approach to increase the life expectancy.

Purpose of this study is to identify factors that affect life expectancy in Mongolia such as GDP per capita, health expenditure per capita and urbanization, using ordinary least squares regression analysis

2. LITERATURE REVIEW

Life expectancy is one of the most vital issue in social sector. Also there are many experts and researchers examine the socio-economic indicators that affect life expectancy. These studies illustrate that developed countries focus on social sectors that include health, education, environmental management and other social welfare mostly. Furthermore, the findings noted that per capita income, poverty reduction in developing countries, high literacy rates for adults, improving hygiene, and improving food quality are influence beneficially on life expectancy.

Navarro and the partners remarked that improving public health expenditures and increasing medical service have enhance the quality of life for the population. (Elola, 1995)

According to the research work performed by Moser and Vajero, life expectancy is expected to grow over the long run but all countries

are different, specially developing countries are outdated. (Moser, 2005)

The third lecture taught about critical reading. In the part of defining critical reading, I found myself always read books passively and recklessly. When I have to read textbooks, this will happen easily. Some contents of those textbooks are quite long and boring. Just as now I am studying Microeconomics, I should read the whole chapter to get more information and concepts about this subject. But I don't think it is easy to read. The sentences are long and hard to understand. And those examples are cases in America. As I know very little about politics and economics, let alone American politics and economics, when I read this textbook, I often cannot get concise concept and write summary.

Miss recommends us to jot notes when we read: after understanding every paragraphs, write down the words in my own expression. It is more useful for use to re-read. I quite agree with her point. When I was in F.6, I retook the HKCEE in Chemistry. In that year, I jotted down all the important points into other points into another book. Then at the day I had my exam, I just read that book instead of bringing four textbooks. Although I spent much more time to write my own notes, the result proved that this method worked. However, as we now studying further, it is not same as HKCEE. The syllabus is much more detail. If I still use this method in my present study, I am sure I cannot follow the rate of progress of the syllabus. Thus, I do not use this method now. But is there any other method good for me to apply?

I also have a question: We spent almost the whole lecture to talk about argument, how to distinguish it from other statements and identify the sentences to see if they are premise or conclusion. Yet what is the use of identifying a statement as an argument? Is that what we need to know when we can judge or with other uses?

I got many difficulties and questions in writing this second reflective journal. At first, I think I know well to write journal, but later, I don't think so. Do I need to write every reflective journal referring to the previous lecture or tutor? I cannot apply them so quick and see if they work for me.

The content of the third lecture is quite hard for me to apply in my daily life. Apart from the above mentioned problem, I also have a question of what I learnt from the third session. At that tutor session, we focused on evaluating the author's tone and works, the choice of evidence, the validity of the evidence. I think these points can be tried only when I read a commentary or article. If I am reading some storybooks or textbooks, can I still apply them?

Well, in tertiary education, one important skill is to speed up the reading pace, but not necessarily comprehend less. It takes time. Practice makes perfect.

We need to at least have statements in order to have argument. Otherwise, there is nothing to be criticised & reasoned, i.e. it's important to tell whether a sentence is actually a statement

No. Anything relevant to your learning or in the course will do.

I am no rush in seeing application. Struggling with new concepts takes time.

Probably non-statements. If so, do we have to reason so harshly?

Sample entry 2

Here is a sample entry of reflective journal writing from one of the junior students who study at the Mongolian National University of Education. The purpose of this reflective journal is to examine the effect of reflective journals on students' learning, give students freedom to understand their own learning and reflect on what they have learnt from the experience. The following are the questions to reflect on students' own learning.

1. What and how did you learn from the lesson?
2. What helped you to study successfully?
3. What tasks and activities did you do in order to improve English language skills independently?
4. What difficulties or problems do you face when you learn English? What are the causes?
5. How do you solve the problems?
6. What are the steps and strategies will you use to solve the problems or difficulties?

No	Research questions	Student 1	Student 2
1	What did you learn from the lesson? How did you learn?		
2	What helped you to study successfully?	<i>Studying successfully depends on me a lot. Teacher, colleagues and my family push me and motivate me to learn successfully.</i>	
3	What tasks and activities did you do in order to improve English language skills independently?	<i>Recently, I have been concentrating on developing vocabulary skill like memorizing new words, reading, collecting information and summarizing. Written this note on the 25th, March.</i>	<i>I have decided to listen to British council podcast every day because it is advantageous to listen even there is no internet connection. I know that there should be an improvement on my language skills if I make an effort on practicing. Written this note on the 22nd, March. I watch movie "Friends" Written this note on the 21st, March.</i>
4	What difficulties or problems do you face when you learn English? What are the causes?	<i>I face some problems for example, I sometimes do not understand the lesson, cannot find the necessary materials related to the lesson, I do not like when others interrupt me and sometimes I get lazy when I work on my assignment or do homework. /03.25/</i>	<i>I could not differentiate the tasks with false and not given well but now I understand how to do it.</i>

5	How do you solve the problems?	<i>I understood that if I do not complete the tasks on time it will be difficult to understand them. I solve the problems by studying alone in quiet place to concentrate well.</i>	<i>Today I have learnt how to do the IELTS reading exercises on true, false and not given. I need to practice a lot on these exercises. If no there will be confusion between them.</i>
6	What are the steps and strategies will you use to solve the problems or difficulties?	<i>In further, I am going to make notes about my lesson Highlight the activities to complete Ask advice from teachers when I complete the tasks independently. Try to understand the lesson on time. /03.25/</i>	<i>I will tick what I have done and what I have not, write my further plan, make some notes on what problems I faced. The above are important strategies to complete the tasks.</i>

From these entries, it can be seen that participant tried to answer the questions given as a guideline. However, their answers did not really show deep reflection. Nevertheless, he/she was not able to use journal writing to set their goals after they knew their problems. Rather, the/she used journal writing simply to answer the questions asked by the tutor. What the researcher/tutor gained from the journals was the reassurance that the students understood the content of the course because they explained what they had learned. What seemed to be missing was a realization about the benefits of a journal as a tool for self-assessment, even though they were expected to use it to assess their learning.

5. CONCLUSION

The strength of reflective journaling lies in the collaborative opportunities for the instructor and student to employ common criteria to

critique the student's reflective skills through journal entries. Consequently, because the instructor is not the sole reviewer, the student learns necessary skills of self-reflection and self-assessment. As Baldwin (1991) stated, "Writing bridges the inner and outer world and connects the paths of action and reflection" (p. 9). Thus, students who master the skills of reflective journaling gain an ability to connect their internal processes with their external realities. The connecting of inner and outer world experiences is a process that demands self-awareness and self-knowledge necessary for the practice of counseling, as well as other professions. As a glass mirror reflects a visual image, the paper mirror reflects students' inner worlds and making of meaning. By providing a means for sharing student reflections, coupled with instructor feedback resulting in ongoing dialogue, the paper mirror can provide the instructor and students valuable information about students'

progression and development. An ultimate goal in professional education is for students to synergize theories with their personal styles, broaden their repertoires of professional methods, inculcate professional ethics into their practices, and develop a base of knowledge that is the foundation for becoming well-rounded, model practitioners. The paper mirror reflects the student's struggles, questions, frustrations, and successes. As Dewey stated (1933), "The function of reflective thought is, therefore, to transfer a situation in which there is experienced obscurity, doubt, conflict, disturbance of some sort, into a situation that is clear,

coherent, settled and harmonious" (p. 100-101).

Journal writing is both a product and a process that helps us "capture an experience, record an event, explore our feelings, or make sense of what we know" (Boud, 2001, p. 9). Using guided reflective journal writing to capture students' experiences, perspectives and stories — their perceptions and perceptual changes — as they participate in various learning experiences provides educators with a unique technology for assessing cognitive and perceptual changes that are hard to measure with conventional evaluation methods (e.g., exams, essays).

REFERENCE

1. Wilson H,W. (2002) Demystifying Reflection: A Study of Pedagogical Strategies That Encourage Reflective Journal Writing University of Kentucky. Teachers College Record Volume 104, Number 7, October 2002, pp. 1393-1421
2. Reflective Journals and Learning Logs, Northern Illinois University, Faculty Development and Instructional Design Center facdev@niu.edu, <http://facdev.niu.edu>, 815.753.0595
3. Hinda Hussein. (2018) Examining the Effects of Reflective Journals on Students' Growth Mindset: A Case Study of. Tertiary Level EFL Students in the United Arab Emirates Higher Colleges of Technology, United Arab Emirates, 36-41
4. Delaura L. Hubbs & Charles F. Brand. (2005) The Paper Mirror: Understanding Reflective Journaling Journal of Experiential Education · Volume 28, No. 1 pp. 60-71
5. Zi-ying Lee (2015) The Reflection and Self-Assessment of Student Interpreters through Logbooks: A Case Study Submitted for the degree of Doctor of Philosophy Heriot-Watt University School of Management and Languages, 19-47

6. Joanna C, D. (2006) Using Guided Reflective Journaling Activities to Capture Students' Changing Perceptions Volume 50, Number 6 20-24
7. Ernesto Panadero & Anders Jonsson & Juan Botella (2017) Effects of self-assessment on self-regulated learning and self-efficacy: Four meta analyses, 4-23
8. Margaret m. BRADLEY and PETER J. Lang (1994) MEASURING EMOTION: THE SELF-ASSESSMENT MANIKIN AND THE SEMANTIC DIFFERENTIAL University of Florida .I. B&w Thu. & Exp. Psvchrar. Vol. 25, No. I. pp. 49-59,
9. Wilaksana Srimavin & Pornapit Darasawang (2004) Developing self-assessment through journal writing 1-3
10. Yoko Suganuma Oi Self-Assessment of Topic Development in Written Production among High School Students, Waseda University. Pan-Pacific Association of Applied Linguistics 18(1), 145-170
11. Nakisa Heidarian (2016) Investigating the Effect of Using Self-Assessment on Iranian EFL Learners' Writing Islamic Azad University Urmia Branch Faculty of Humanities Department of English Vol.7, No.28, 80-84
12. Zamira Gashi Shatri & Naser Zabeli (2018) Perceptions of students and teachers about the forms and student self-assessment activities in the classroom during the formative assessment 9 (2), 28-46
13. A. I. N. Marhaeni& Ni Made Ratminingsih & L. P. D. Vigayanti. (2018) Self-Assessment: The Effect on Students' Independence and Writing Competence Vol.11, No.3
14. Anastasia Papanthymou, & Maria Darra (2018) Student Self-Assessment in Higher Education: The International Experience and the Greek Example Vol. 8, No. 6; 130-133
15. Panadero, E., Jonsson, A., & Strijbos, J. W. (2016). Scaffolding self-regulated learning through self-assessment and peer assessment: Guidelines for classroom implementation. In D. Laveault & L. Allal (Eds.), *Assessment for Learning: Meeting the challenge of implementation* 4-7
16. EducationJane Pilling, B.Com., B.A., B.Ed. (1990) The Assessment of Self-Directed Learning Among Pre-Service students in an ontario Faculty of Department of Graduate and Undergraduate Studies in Education Faculty of Education Brock University st. Catharines, Ontario
17. Ernesto Panadero, Gavin Brown & Jan-Willem Strijbos (2015) The future of student self-assessment: A review of known unknowns and potential directions

Article info: Mandakh Research, 2020, HUM 304, Vol.03, 87-95

ЭКОНОМЕТРИКИЙН ХИЧЭЭЛИЙГ СУДАЛЖ БУЙ ОЮУТНУУДЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ТАНИН МЭДЭХҮЙН ТҮВШНИЙ СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭН ДЭХ НӨЛӨӨЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Эрдэнэхуягийн Мөнхдулам^{1, a*}, Балтын Бадамхүү^{2, b}

^{1,2}Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

^amunkhdulam.e@ufe.edu.mn, ^bbadamhuu.b@ufe.edu.mn

Хураангуй

Бидний судалгааны зорилго нь эконометрикийн хичээл үзээж буй оюутнуудын өөрийн үнэлгээ ба танин мэдэхүйн түвшин нь сургалтын үнэлгээнд нөлөөлөх нөлөөллийг илрүүлэхэд оршино. Судалгаанд 2019-2020 оны хичээлийн жилд эконометрикийн хичээлийг судалсан 137 оюутныг санамсаргүй түүврийн аргаар бүрдүүлэн хамруулсан ба оюутнуудын эконометрикийн хичээлийн явцын 1-р шалгалтын дүн, өөрийн үнэлгээний 7 асуулт, танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох 12 асуулт бүхий төстийн үр дүнг тус тус ашигласан болно. Шинжилгээгээр оюутны өөрийн үнэлгээ болон танин мэдэхүйн түвшин нь сургалтын үр дүнд эерэг нөлөөтэй [$r=0.5$, $r=0.3$, $p<0.05$] болох нь тодорхойлогдлоо.

Түлхүүр үг: Пирсоны корреляцийн коэффициент, хамаарал, явцын шалгалтын дүн

1. ОРШИЛ

Эконометрикийн шинжлэх ухаан нь сүүлийн үеийн өгөгдлийн шинжилгээ, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан зэрэг салбар эрчимтэй хөгжиж буй энэ нийгэмд хэрэглээ ихтэй болж байна. Үүнийг эконометрикийн хичээлийг дэлхийн бүх орны их, дээд сургуулийн мэргэжлийн анги бүрт эконометрик буюу өгөгдлийн шинжилгээ гэсэн нэртэйгээр оюутнууд үзэж, судалж байгаагаас харж болно. Мөн аль ч талбарын эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгаанууд загварчлалын арга зүйгээр баяжигдсан байдаг. Эконометрикийн арга зүй нь эдийн засаг, менежмент, санхүү, нягтлан бодох бүртгэл, программ хангамж зэрэг хэрэглээний математик, статистикийн онолын арга зүйд суурилан шинжлэх ухаан хоорондын заагт хөгжиж буй бөгөөд эдгээр нь загварчлах, тооцоолол хийх, таамаглах, үйл явцыг дүгнэх, харьцуулалт хийх, нэгтгэн дүгнэх, шийдвэр гаргах, цаашлаад үзэл бодлыг төлөвшүүлэх зэргээр хэрэглэгддэг.

Суралцагчдын математикийн хичээлийн ололт амжилт нь маш олон зүйлст нөлөөлдөг талаарх судалгаанууд байдаг. Тэдгээрийн бас нэг чухал хүчин зүйл нь суралцагчийн өөрийн үнэлэмж, танин мэдэхүйн үйлийн түвшин юм. (Кэмпбелл, Хакет, 1986), (Хакет, Битз, Охаллоран, Ромак,

1990) нар нь суралцагчийн математикийн хичээлийн чадвартаа итгэх итгэл нь математикийн хичээлийн амжилтанд нь нөлөөлдөг болохыг тогтоосон байдаг.

Танин мэдэхүйн үйлүүд нь суралцагчийн сурлагын амжилтанд эерэг нөлөөтэй бөгөөд “Хэзээ? Яаж?” хэрэгжүүлэх вэ? гэдгээс хамаардаг (Меткалфе, Шимакура 1994). Малайз улсад 1997 оноос танин мэдэхүйн үйлүүдийг сургалтанд ашиглах талаар баримт бичиг гарч байжээ. Танин мэдэхүй гэдэг нь мэдлэгийн төлөө мэдэх, суралцахууд суралцах, бодлын талаар бодох зэрэг ойлголтуудыг илэрхийлдэг бөгөөд бидний бодлын гурван чухал зүйл болох үйл явц, удирдлага, итгэл үнэмшлийг өөртөө багтаадаг (Шөвнфелд 1987, 1992). Иймээс танин мэдэхүйн үйл нь суралцагчдад суралцахуын арга барилыг эзэмшихэд тусалдаг.

Танин мэдэхүйн үйлүүд нь суралцагчдын математикийн амжилтанд нөлөөлдөг талаарх хэд хэдэн судалгаа бий. Жишээ нь: Озсойн (2010) онд хийгдсэн судалгаагаар хамаарлын хүч нь 0.65, магадлалын утга нь 0.01 -ээс бага гарч байжээ.

Эдгээр танин мэдэхүйн үйлүүд нь стресс бухимдал ихтэй энэ нийгэмд хувь хүн өөрийгөө олох, бусдыг таньж мэдэх, сайн муу, үнэн худлыг ялгаж салгахад их хэрэгтэй. Үүнийг нотлон “critical thinking” буюу “нухацтай сэтгэлгээ” гэх

сургалт, хэлэлцүүлгүүд сүүлийн үед хүний хөгжлийн зарим сургалтын төвүүд болон их, дээд сургуулиудын оюутны клубууд дээр явагддаг болжээ.

Нөгөө талаас суралцагчийн математикийн суурь мэдлэгийн талаарх өөрийн үнэлгээ нь математикийн хичээлийн үнэлгээнд нь нөлөөлдөг байна. Энэ талаарх судалгаануудыг Бандура (1986), Хакет, Битз, Шанк (1991) нар хийсэн байна. Ер нь хүний “би чадна” гэх итгэл нь ямар ч үйл явц, үр дүнд эерэг нөлөө үзүүлдэг болох олон жишээг бид өдөр тутмын амьдралаасаа мэдэрч, мөн олон ном, зохиолоос уншиж байна.

2. АРГА ЗҮЙ

Уг судалгаанд 2019-2020 оны хичээлийн жилд эконометрикийн хичээлийг судалсан 137 оюутныг санамсаргүй түүврийн аргаар бүрдүүлэн хамрууллаа. Мэдээллийг баримт бичгийн болон асуулгын аргаар цуглуулсан ба 137 оюутны эконометрикийн хичээлийн явцын 1-р шалгалтын (Энэхүү хичээлийг үзэж байгаа бүх группын оюутнаас яг ижил агуулга бүхий шалгалтыг яг ижил цаг хугацаанд нэгэн зэрэг авдаг болно) дүн болон өөрийн үнэлгээний 7, танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох 12 асуулт бүхий тестийг хариулсан үр дүнг ашигласан болно.

Өөрийн үнэлгээний 7 асуулга нь оюутны эконометрикийн

хичээлийг сайн дүнтэй төгсөж чадна гэсэн итгэлийг хэмжих зорилготой. Танин мэдэхүйн түвшний 12 асуулга нь оюутны эконометрикийн хичээлийг суралцахдаа хэрэгжүүлдэг үйлүүдээс тогтоно. Асуулт тус бүр нь дөрвөн хариулттай бөгөөд 1-ээс 4 хүртэлх шкалаас сонгоно. Энд “1 - үнэхээр санал нийлэхгүй”, “2 - санал нийлнэ”, “3 - санал нийлнэ”, “4 - үнэхээр санал нийлнэ” гэсэн утгыг тус тус илэрхийлнэ.

Судалгааны зорилт:

1. Оюутнуудын өөрийн үнэлгээний түвшинг тогтоох
2. Оюутнуудын танин мэдэхүйн түвшинг тогтоох
3. Оюутнуудын сургалтын үнэлгээ болон өөрийн үнэлгээ, танин мэдэхүйн түвшин хоорондын хамаарлыг тогтоох

Үр дүн:

Оюутнуудын өөрийн үнэлгээний асуулга, танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох асуулгын үр дүн, тэдгээрийн сургалтын үр дүнтэй хамаарч байгаа эсэх талаарх үр дүнг энд багтаалаа.

3. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

3.1 Эконометрикийн хичээлээрх оюутнуудын өөрийн үнэлгээ

Судалгаанд хамрагдсан нийт оюутны эконометрикийн хичээлээрх өөрийн үнэлгээний

ерөнхий дундаж 3.2, стандарт итгэлтэй байгааг харуулж байна. хазайлт 0.4 гарсан. Энэ нь Оюутнуудын асуулга бүрийн хувьд оюутнууд өөрсдийгөө хичээл хэрхэн хариулсан байдлыг доорх дээр нэлээд сайн үнэлэгдэнэ гэсэн хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 1. Оюутны өөрийн үнэлгээний асуулгад хариулсан байдал

	Асуулт	Үнэхээр санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Санал нийлнэ	Үнэхээр санал нийлнэ	Дундаж	Стандарт хазайлт
1	Би эконометрикийн хичээлдээ маш сайн дүн авна гэдэгтээ итгэлтэй байгаа.	0%	13%	70%	17%	3.0	0.56
2	Би эконометрикийн хичээл дээрх багшийн заасан чухал ойлголтыг сурч чадна гэдэгтээ итгэлтэй байна.	0%	4%	61%	35%	3.3	0.56
3	Би багшийн заасан эконометрикийн хичээлийн хамгийн хэцүү ойлголтыг сурч чадна гэдэгтээ итгэлтэй байна.	0%	13%	74%	13%	3.0	0.52
4	Би өгсөн дасгал ажлыг гүйцэтгэж чадна гэдэгтээ итгэлтэй байна.	0%	9%	61%	30%	3.2	0.60
5	Би энэхүү эконометрикийн хичээлийг хамаг сайнаараа хийж чадна гэдэгтээ итгэлтэй байна.	0%	13%	57%	30%	3.2	0.65
6	Би энэ хичээлээр олгох, шаардлагат ур чадваруудыг эзэмшиж чадна гэдэгтээ итгэлтэй байна.	0%	9%	70%	22%	3.1	0.55
7	Эконометрикийн хичээл хэцүү ч гэсэн, би маш сайн хийж чадна гэдэгтээ итгэлтэй байна.	0%	9%	52%	39%	3.3	0.63

Судалгаанд оролцсон оюутнуудын дийлэнх нь өөрийгөө дунд болон өндрөөр үнэлсэн бөгөөд цөөнх оюутан энэ хичээлийг амжилттай давна гэдэгтээ итгэлгүй байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

Оюутнуудын өөрийн үнэлгээний асуулга дээр Кронбах Альфа буюу найдвартай байдлын коэффициент тооцоход 0.85 гарлаа. Кронбах Альфа > 0.6 байхад найдвартай гэж үздэг ба бидний асуулга ач холбогдолтой болохыг илтгэж байна.

Зураг 1. Оюутнуудын өөрийн үнэлгээний асуулгын найдвартай байдал

Reliability Statistics

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.855	.851	7

3.2 Танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох асуулга, үр дүн

Судалгаанд хамрагдсан нийт оюутны эконометрикийн хичээлээрх танин мэдэхүйн түвшний ерөнхий дундаж 2.8,

стандарт хазайлт 0.3 гарсан. Энэ нь оюутнууд танин мэдэхүйн дунд түвшинд байгааг илтгэнэ. Оюутнууд асуулга бүрийн хувьд хэрхэн хариулсан болохыг доорх хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 2. Оюутнуудын танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох асуулгад хариулсан байдал

		Үнэхээр санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Санал нийлнэ	Үнэхээр санал нийлнэ	Дундаж	Стандарт хазайлт
1	Эконометрикийн хичээлийн лекцийн үеэр би анхаарлаа сарниулснаасаа болж чухал зүйлсийг нэлээд их алддаг.	9%	17%	48%	26%	2.9	0.90
2	Шалгалтын үеэр анхаарлаа сайн төвлөрүүлэхийн тулд өөрөөсөө асуулт асуудаг.	17%	26%	39%	17%	2.6	0.99
3	Эконометрикийн хичээлийн ямар нэг ойлголтонд эргэлзсэн үедээ би шийдлийг нь заавал олдог.	0%	30%	61%	9%	2.8	0.60

4	Би эконометрикийн хичээлийг суралцах явцдаа суралцахуйн ямар нэг бэрхшээлтэй тулгарвал, суралцах арга барилаа өөрчилнө.	0%	35%	48%	17%	2.8	0.72
5	Би эконометрикийн хичээлийн шинэ ойлголтыг суралцахаасаа өмнө, холбогдох сургалтын материалтай ажилладаг.	9%	52%	30%	9%	2.4	0.78
6	Би эконометрикийн хичээлийн лекцийн ойлголтоо баталгаажуулахаар сэдэвт холбогдох асуултыг өөрөөсөө асуудаг.	9%	48%	35%	9%	2.4	0.79
7	Би эконометрикийн хичээл болон багшийн шаардлагын дагуу суралцах хэв маягаа тохируулж чадна.	0%	17%	70%	13%	3.0	0.56
8	Би энэ хичээл дээр үргэлж төөрөлддөг.	13%	39%	43%	4%	2.4	0.78
9	Би тодорхой сэдвийн хэрэгцээ шаардлагын дагуу эконометрикийн хичээлийг судалдаг.	4%	13%	70%	13%	2.9	0.67
10	Би шалгалт өгч байхдаа, өмнө ойлгоогүй агуулгаа ойлгож авдаг.	0%	4%	48%	48%	3.4	0.59
11	Би энэ хичээл эхлэх үед өөртөө зорилт тавьсан.	9%	22%	48%	22%	2.8	0.89
12	Тэмдэглэл хөтлөж байхад эргэлзэх зүйл гарвал, би уг ойлголтыг дараа нь баталгаажуулж авдаг.	9%	13%	65%	13%	2.8	0.78

Дээрх асуултуудын хувьд хамгийн өндөр дундажтай байгаа нь 10-р асуулт буюу “Би шалгалт өгч байхдаа, өмнө ойлгоогүй агуулгаа ойлгож авдаг” агуулгатай байгаа ба энэ нь эконометрикийн хичээлийн шалгалт нь олон ойлголтыг агуулсан цогц ажилбаруудтай байдагтай холбоотой гэж үзэж байна. Дараагийн өндөр дундажтай асуулт нь 7 бөгөөд энэ нь сүүлийн үеийн хүүхдүүдийн шинэ соргог зүйлд дасан зохицох чадвар өндөртэй байгааг илэрхийлэх сайн үзүүлэлт юм. Гурав дахь өндөр дундаж нь 2.9 бөгөөд 1 болон 9-р асуултуудад гарчээ. “Би тодорхой сэдвийн хэрэгцээ шаардлагын дагуу эконометрикийн хичээлийг судалдаг” гэсэн асуултын дундаж өндөр байгаа нь мөн л эерэг үзүүлэлтийг илтгэх бөгөөд оюутнууд хичээлийнхээ хэрэгцээ, шаардлагыг маш сайн мэддэг болохыг илэрхийлж байна.

Харин 1-р буюу “Эконометрикийн хичээлийн лекцийн үеэр би анхаарлаа сарниулснаасаа болж чухал зүйлсийг нэлээд их алддаг” гэсэн

Зураг 2. Оюутнуудын танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох асуулгын найдвартай байдал

Reliability Statistics

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.593	.592	12

асуултын дундаж ийнхүү өндөр байгаа нь тийм ч эерэг зүйл биш ба энэ нь хичээлийн агуулга их, хүндэвтэр байх онцлогоос улбаатай юм.

Оюутнуудын танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох асуулга дээр Кронбах Альфа буюу найдвартай байдлын коэффициент үнэлэхэд 0.59 гарлаа. Үүнийг найдвартай байдал хангалттай биш гэж үнэлэхээр байна.

Бид өөрийн үнэлгээний болон танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох асуулгыг нэгтгэн Кронбах Альфа буюу найдвартай байдлын шинжилгээ хийхэд 0.73 гарлаа. Энэ нь бидний судалгааны хувьд бүхэлдээ хүлээн зөвшөөрч болохуйц ач холбогдолтойг илтгэж байна.

Зураг 3. Оюутнуудын өөрийн үнэлгээний асуулга болон танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох асуулгын найдвартай байдал

Reliability Statistics

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items
.727	.762	19

3.3 Оюутны өөрийн үнэлгээ, танин мэдэхүйн түвшин, сургалтын үнэлгээ хоорондын хамаарал

Энэ хэсэгт оюутнуудын сургалтын үнэлгээ нь оюутны өөрийн үнэлгээ болон танин

мэдэхүйн түвшинтэй хэрхэн хамаарч байгааг Пирсоны корреляцийн коэффициент тооцооноор шинжиллээ.

Хүснэгт 3. Оюутнуудын сургалтын үнэлгээг, өөрийн үнэлгээ болон танин мэдэхүйн түвшний асуулгын үр дүнтэй тус тус корреляцийн коэффициент тооцсон байдал

	r	P - value
Оюутны өөрийн үнэлгээ	0.5	0.000
Танин мэдэхүйн түвшин	0.3	0.000

Оюутны сургалтын үнэлгээний оюутны өөрийн үнэлгээ болон танин мэдэхүйн түвшин хоорондын хамаарлын хүч нь харгалзан 0.5, 0.3 гэж тооцогдсон ба үндсэн таамаглал биелэх магадлалын утга нь 0.000 байгаа нь коэффициент эх олонлогийн хувьд ач холбогдолтойг илэрхийлж байна.

4. ДҮГНЭЛТ, САНАЛ

Танин мэдэхүйн үйлүүд болон суралцагчийн математикийн суурь мэдлэгийн талаарх өөрийн үнэлгээ нь суралцагчдын математикийн төрлийн хичээлийн амжилтанд нөлөөлдөг болохыг тодорхойлсон үр дүнгүүдийг ном зүйн тойм судалгааны хүрээнд авч үзлээ.

Бидний түүвэр судалгааны асуулга найдвартай /Кронбах альфа=0.73/ бөгөөд судалгаанд баримт бичгийн болон асуулгын аргыг ашиглалаа. 137 оюутныг түүвэрлэн, тэдний эконометрикийн хичээлийн явцын 1-р шалгалтын

дүн болон өөрийн үнэлгээний 7, танин мэдэхүйн түвшнийг тодорхойлох 12 асуулт бүхий тестийн үр дүнг ашиглалаа.

Судалгааны явцад нийт оюутны танин мэдэхүйн /хүснэгт 1/ дундаж түвшин дунд, өөрийн үнэлгээний /хүснэгт 2/ дундаж түвшин өндөр гэж үнэлэгдсэн ба оюутнуудын сургалтын үнэлгээ болох явцын шалгалтын үнэлгээнд оюутны өөрийн үнэлгээ болон танин мэдэхүйн түвшин нь эерэг нөлөөтэй гэж тодорхойлогдсон. Танин мэдэхүйн түвшний сургалтын үнэлгээтэй хамаарах хамаарлын хүч нь Озсойн үр дүнтэй харьцуулахад бага утгатай үнэлэгдсэн ч эерэг хамааралтай гэдэг нь нийцэмжтэй байна. Энэ эерэг хамаарлаар сургалтын үнэлгээ өндөртэй оюутнууд өөрийн суурь мэдлэг, суралцах чадварын түвшинг зөв үнэлснээрээ хичээлээ амжилттай дүүргэх итгэлийг олж авдгийг харуулж байна.

Нэгтгэн дүгнэвэл, сургалтын үйл ажиллагаа амжилттай байх үндэс нь суралцагчдын итгэл төдийгүй энэ нь суурь мэдлэгийн талаарх өөрийн үнэлгээ, танин мэдэхүйн түвшний үнэлгээгээр илэрхийлэгдэнэ.

Суралцагч бүр цаашид амжилттай суралцаж, сайн сайхан амьдарч, гэр бүлдээ болон нийгэмд өөрийн хувь нэмрээ оруулахын тулд суурь мэдлэг, чадвараа чамбай эзэмшихийн сацуу аливааг танин мэдэх аргад суралцах, чадвар дадал болгох нь зүйн хэрэг юм.

Багш бид ч суралцагчид энэ талаас нь зөвлөн чиглүүлж, чадваржуулах нь урт хугацаанд эерэг нөлөөг суралцагч бүрт, цаашлаад нийгэмд авчирна гэдгийг чиг баримжаа болгон ажиллах хэрэгтэй юм.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Bandura, A. (1977). Self-efficacy: Toward a unifying theory of behavioral change. *Psychological Review*, 84(2), 191-215.
2. Campbell, N. K. & Hackett, G. (1986). The effects of mathematics task performance on math self- efficacy and task interest. *Journal of Vocational Behavior*, 28, 149-162.
3. Hackett, G., Betz, N. E., O'Halloran, M. S., & Romac, D. S. (1990). Effects of verbal and mathematics task performance on task and career self-efficacy and interest. *Journal of Counseling Psychology*, 37, 169-177.
4. Metcalfe, J., & Shimamura, A.P. (1994). *Metacognition: Knowing about knowing*. Cambridge, MA: MIT Press.
5. Ozsoy, G. (2010). An Investigation of the relationship between Metacognition and Mathematics Achievement. *Asia Pacific Edu. Rev.*
6. Schunk, D.H. (1991). Self-efficacy and Academic Motivation. *Educational Psychologist*, 26, 207-231
7. Schoenfeld, A. H. (1992). Learning to think mathematically: problem solving, metacognition, and sense-making in mathematics. In D. Grouws, (Ed.). *Handbook for Research on Mathematics Teaching and Learning*. New York: MacMillan. pp. 334-370.

Abstract

The purpose of this study is to determine the econometrics self-assessment and meta-cognition among our students. One hundred thirty-seven respondents from a university of finance and economics in Mongolia were chosen through random sampling. These students had studied basic econometrics in this academic year. Econometrics performance, the test of self-efficacy and metacognition was used in this study. Further analysis shows that there is a positive relationship between econometrics performance and econometrics self-efficacy [$r = 0.5$, $p < 0.05$] and also econometrics meta-cognition [$r = 0.3$, $p < 0.05$].

Key words: Pearson's correlation coefficient, relationship, result of the examination in progress

БАЯЖУУЛСАН ШИМ БОРДООГ ҮРЭЛЖҮҮЛЭХ ТӨХӨӨРӨМЖИЙГ ТУРШСАН ДҮН

Г.Уранбилэг^{1,a}, Б.Мөнх-Эрдэнэ^{2,b}, Д.Баатархүү^{3,c*}

¹МҮИС, УУЭХИС, МИХБ-ийн багш

^{2,3}ХААИС, Инженер, технологийн сургууль

^ag.uranbileg@mnun.edu.mn, ^bb.munkherdene@muls.edu.mn,

^celec_eng@muls.edu.mn

Хураангуй

Манай орны газар тариалангийн үйлдвэрлэд хөрсний үржил шимийг сайжруулах, ургац нэмэгдүүлэх зорилгоор бордоог зайлиггүй хэрэглэх шаардлагатай байдаг. Тус судалгааны ажлаар үрлэн бордоо үйлдвэрлэх төхөөрөмжийн технологи ажиллагааны зарим үзүүлэлтийн зохимжтой утгыг тодорхойлж, бордооны физик механик шинжүүдийг лабораторийн нөхцөлд туршиж бяцралт, нягт ба эзэлхүүн жин, чийг болон дотоод үрэлтийн илтгэлцүүрийг тодорхойлов.

Түлхүүр үг: бордоо, үрэл, эргэлт, өнцөг

1. ОРШИЛ

Манай орны ХАА-н эдэлбэр газрын ихэнх хэсэг ялзмаг үе давхаргаар хангалтгүй азот, фосфор, молбиден, иод, цайр зэрэг ургамлын өсч хөгжихөд чухал язгуур элементүүдээр дутмаг ихэнхдээ элс ба элсэнцэр, чулуун хольц давамгайлсан ус, чийг дутагдалтай, хуурайшил ихтэй болохоор ургамалын гарц төдийлөн сайнгүй байна. Иймээс хадлан бэлчээр, үр тариа төмс, хүнсний ногооны ургацыг тогтвортой нэмэгдүүлэхийн тулд хөрсний тэжээлийн бодис, чийгийн хангамжийг нэн тэргүүнд оновчтой шийдвэрлэх асуудал хурцаар тавигдах боллоо (Чойжамц, 2011).

“Атрын гуравдах аян” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ургамал газар тариалан эрдэм шинжилгээний хүрээлэнгийн лаборатори нь газар тариалан эрхэлдэг 15 аймгийн 102 сумын 1942 аж ахуй нэгж, иргэдийн 579,3 мянган га талбайгаас 15790 ширхэг дээжийг бүрдүүлэн авч хөрсний агрохимийн шинжилгээг Тариалангийн тухай хуулийн 16.4-т заасны дагуу хөрсний ялзмаг, нитратын азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, хөрсний бүхэлшилт, хөрсний элэгдэл эвдрэл, хөрсний орчин гэсэн 7 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна.

Шинжилгээний дүнгээс үзэхэд тариалангийн талбайн 60,6 % нь хүчтэй элэгдэлд орсон, ихэнхи

бүс нутгийн хөрсний үржил шим дундаас доогуур үзүүлэлттэй байна. Манай улсын тариалангийн нийт талбайн 60 орчим хувь нь ургамалд хялбар ашиглагдах азот, калиар, 34.7% нь фосфорын агууламжаар тус тус бага хангамжтай байгаа нь шинжилгээний дүнгээр тогтоогдов (<http://mofa.gov.mn>, 2019).

Иймээс хөрсний шинжилгээний дvн, таримлын физиологийн онцлогт vндэслэн бордоог өргөн ашиглан газар тариаланг эрчимжvвлэх чиглэлээр хөгжvвлэх шаардлага зvй ёсоор тулгарч байна. Цаг уурын эрсдэл ихтэй нөхцөлд газар тариаланг эрхэлдэг манай орны хувьд бордоог системтэй хэрэглэхэд хөрсний үржил шим сайжирч, таримлын ургац бордооны вйлчлэлээс чийглэг жилvвдэд 5.6 ц/га, хэвийн жилvвдэд 3.1 ц/га, гантай ба гандуу жилvвдэд 2.1 ц/га-аар тус тус илvв байгаа нь тогтоогдсон.

Манай орон олон жилийн туршид бордоог гадаадаас экспортлож хэрэглэдэг байсан бол 2013 оноос “Гарааны Монгол Экологийн бордоо” ХХК байгуулагдаж олон улсын стандартын дагуу үйлдвэрлэл явуулж байна. Тус үйлдвэр Франц улсын загвараар бордоог үрэл хэлбэрт оруулан гаргадаг.

Монголын газар тариалан эрхлэгчдийн үр тарих машины үрлэх аппаратны катушканы онцлогоос хамаарч үрэл хэлбэрээр

бордоог үйлдвэрлэх нь илүү тохиромжтой юм. Мөн нунтаг хэлбэрээр үйлдвэрлэхээс тоосжилт багатай байдгаараа давуу талтай. Гэвч уг үйлдвэрийн үрлэн бордоо нь хэмжээний хувьд харилцан адилгүй гарцтай байгаа нь тарималын өсөлт жигд бус болоход нөлөөлж байна.

Иймд тус үйлдвэрийн тоног төхөөрөмж дээр судалгаа явуулж, үрэлжүүлэх төхөөрөмжийн технологи ажиллагааны зарим параметрийг тогтоож, бордооны физик-механикийн шинж чанарыг тодорхойллоо.

2. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

Баяжуулсан шим бордоог газар тариаланд хэрэглэх машинуудын хийцийн параметр болон технологи ажиллагаанд нөлөө үзүүлэх технологийн зарим шинж чанар болох

- Бордооны бяцралт
- Бордооны эзэлхүүн жин болон нягт
- Бордооны хатасны дараах чийгийн агууламжийг лабораторийн туршилтаар тодорхойлов.

Лабораторийн нөхцөлд туршихад дараах тоног төхөөрөмж багаж хэрэгслийг ашиглав.

1. Бордоо үрэлжүүлэх төхөөрөмж

2. Гоожимтгой материалын дотоод үрэлтийн илтгэлцүүрийг (өнцөг) тодорхойлох лабораторийн төхөөрөмж
3. Эзэлхүүн жин тодорхойлох төхөөрөмж
4. Мянган үрийн жин тодорхойлох төхөөрөмж
5. Бяцралт тодорхойлох GWJ-2 төхөөрөмж
6. Хатаах шүүгээ СЭШ-3М

Зураг 1. Туршилтын ерөнхийлсөн загвар

Үүнд:

x_1 - Төхөөрөмжийн эргэлтийн



давтамж, эрг/мин

x_2 - Тавагны налууугийн өнцөг, град

y - 2...5мм хэмжээтэй үрлэн бордооны хэмжээ, гр

$$y = f(x_1, x_2) \rightarrow \max.$$

Дээрх y үзүүлэлтийг илэрхийлэх хүчин зүйлүүдийн түвшинг зөвхөн $X_{идээд}$, $X_{идоод}$ утгаар биш 3 ба 5 түвшинд өөрчилөн Боксын төлөвлөлт буюу II эрэмбийн ротатабель төлөвлөлтийг хэрэглэж тодорхойлсон. Оролтын хүчин зүйлүүдийн зохимжтой утгыг урьдчилсан туршилтаар тодорхойлоход төхөөрөмжийн эргэлтийн давтамж 23 эрг/мин, тавагны налууугийн өнцөг 45° байхад тус бүртээ үрлэн хэлбэрт

орсон бордооны хэмжээ хамгийн их байв. Иймд эдгээр утгуудаар хүчин зүйлүүдийн утгыг үндсэн төвшин болгон авч, үндсэн төвшингөөс хазайх нөлөөлөх

утгыг өөрчлөлтийн бага хүрээгээр хязгаарыг нь тогтоож, 1-р хүснэгтэд харуулсанаар 5 түвшинд авсан.

Хүснэгт 1. Туршилтын нөхцөл

Хүчин зүйлүүд	$-x_\alpha$	$x_{идоод}$	x_{i0}	$x_{идээд}$	$+x_\alpha$	I_i
	-1,414	-1	0	+1	+1,414	
Эргэлтийн давтамж - x_1 , эрг/мин	18,758	20	23	26	27,242	3
Тавагны налуугийн өнцөг - x_2 , град	37,93	40	45	50	52,07	5

3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Судалгааны ажлын туршилтыг лабораторийн нөхцөлд явуулж, хэмжилтийн үр дүнд математик статистик боловсруулалт хийж,

хүчин зүйлүүдийн хамаарлыг илэрхийлсэн олон хүчин зүйлт регрессын загварыг гаргаж авлаа (Авдай, 2019).

$$y = 194.77 - 5.19x_1 - 26.8x_2 - 68.13x_1x_2 - 23.7x_1^2 - 11.69x_2^2 \quad (1)$$


Үрэл хэлбэрт орсон бордооны хэмжээнд тавагны налуугийн өнцөг, эргэлтийн давтамж болон налуугийн өнцгийн хавсарсан үйлчлэл хамгийн их нөлөөтэй байгаа нь харагдаж байна.

Бодит загвараас зохимжтой утгуудыг тодорхойлбол $X_1 = 22$ эрг/мин, $X_2 = 46$ градус гарав.

3.1. Бордооны физик, механик шинж чанар

Баяжуулсан шим бордооны дотоод үрэлтийн илтгэлцүүр болон овоологдох өнцгийг тодорхойлбол дотоод үрэлтийн илтгэлцүүр нь 1.34, овоологдох өнцөг $58,8^0$ байв (Бямбадорж, 2019).

Зураг 2. Үрэлжсэн бордооны бяцралт диаметр хоорондын хамаарал



Үрэлжсэн бордооны бяцралтыг GWJ-2 багажаар 2ч5 мм диаметртэй үрэл тус бүр дээр туршилт явуулан үр дүнг тодорхойлж, дундаж үзүүлэлтээр гаргасан бяцралт үүсгэх хүч, бордооны диаметрийн хоорондын хамаарлыг зураг 2-т харууллаа. Үрлэн бордооны диаметр бяцралт үүсгэх хүчний

хамаарлын тэгшитгэлээс хамгийн их бяцралт үүсэх хүч 35.35Н байхад харгалзах бордооны диаметрт 3.97мм буюу 4мм байв. Харин бордооны эзэлхүүн жинг $594,05 \pm 7,1 \text{ кг/м}^3$, нягт 1140 кг/м^3 байв. Баяжуулсан шим бордоог бүрэн хатсаны дараа хатаах төхөөрөмжинд дээж аван хийж 5 удаагийн туршилтаар чийгийн хэмжээг тодорхойлход бордоонд агуулагдах чийгийн хэмжээ 10,1 % байв.

4. ДҮГНЭЛТ

Бордоо үрэлжүүлэх төхөөрөмжийн эргэлтийн хурд, налууугийн өнгийн зохимжтой утга $X_1 = 22$ эрг/мин, $X_2 = 46^\circ$ байна. Энэ нь нунтаг баяжуулсан шим бордоо хамгийн сайн үрэл хэлбэрт орох нөхцөл болж өгнө. Үрлэн бордоог 3-5кг хэмжээтэйгээр савлах нь тохиромжтой байна. Бордооны дотоод үрэлтийн илтгэлцүүр нь 1.34, чийгийн хэмжээ 10,1%, нягт 1140 кг/м^3 гарав.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. Чойжамц, А. (2011). Ургамлыг бордох менежмент. Улаанбаатар хот: Монгол. 177х
2. <http://mofa.gov.mn/exp/blog/8/77>.
3. Авдай, Ч., Энхтуяа, Д. (2017). Туршилт төлөвлөлтийн математик арга, түүнийг судалгаа шинжилгээний аргад хэрэглэх. Улаанбаатар хот: Монгол. 92х
4. Бямбадорж, Ч. (2012). Хөдөө аж ахуйн машины онол, Улаанбаатар хот. Монгол. 199х

Abstract

Fertilizers must be used for soil fertility and growing crops in our country's agricultural production. It's necessary produce pills, the characteristics of fertilizer technology to determine the technological and technological performance of the machine are tested in laboratory conditions, defining the brittle, dense, volume moisture and internal friction coefficients. Mathematically processed by the results specified and verify several criteria.

Түлхүүр үг: fertilizer, pellets, rotation, angle

